# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр Дугаар 567 Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.4, 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон нийт 17,411,178.00 (арван долоон сая дөрвөн зуун арван нэгэн мянга нэг зуун далан найман) төгрөгийн балансын үнэ бүхий 1 автомашин нь хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй тул автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА А.АРИУНБОЛД

0001120

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугээр сарын 16-ны өдрийн
564 ... дугаар тогтоолын хавсралт

## "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, арал | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он | Явсан км | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг (төгрөг) | 2019 оны 292 дугаар тогтоолоор | Шинэчлэн тогтоосон үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Микро автобус Грейс турбо, 90-08 ДОА, kmjrd27fp3k563463, р3-793511 | 2003/2009 | 220,463 | 17,411,178.00 | 17,411,178.00 | - | 2,000,000.00 | 1,100,000.00 |
| Нийт дүн | | | | **17,411,178.00** | **17,411,178.00** | **-** | **2,000,000.00** | **1,100,000.00** |
| | | | | **(арван долоон сая дөрвөн зуун арван нэгэн мянга нэг зуун далан найман)** | | | **(хоёр сая)** | **( нэг сая нэг зуун)** |